

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2024.09.02

Орхон аймаг

Байгууллагын дотоод хяналт, шалгалтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хүрээнд байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2024 оны 09 дүгээр сарын 02-13-ны хооронд байгууллагын дотоод хяналт, шалгалтыг зохион байгууллаа.

1.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХЭД:

2024 оны эхний хагас жилийн байдлаар БОАЖГ-т Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгавар зэрэг нийт 47 тогтоол, шийдвэрийн 63 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Нийт 63 хяналтад авсан заалтуудын 10 заалт (15.8%) нь бүрэн биелэгдсэн, 46 заалт (73%) хэрэгжилтийн шатанд, 6 заалт (9.5%) хэрэгжилт хангалтгүй, 2 заалт (3%) хугацаа болоогүй үнэлэх боломжгүй байна. Хэрэгжилтийн үнэлгээ дунджаар хувь 70.89%-тай дүгнэгдсэн байна.

Тодруулбал: 10 заалт 100 хувь, 46 заалт 70 хувь, 6 заалт 30 хувийн хэрэгжилттэй, 2 заалтын хэрэгжилтийн хугацаа болоогүй үнэлгээтэйгээр дүгнэгдэв.

Хяналтад авсан тогтоол, шийдвэрийг ангилан харуулбал:

№	Эрхзүйн баримт бичиг	Шийдвэрийн тоо, бүлэг	Зүйл, заалтын тоо	Үнэлгээ хувь
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр				
1.	МУ-ын хууль	4	4	70%
2.	МУИХ-ын Байнгын хорооны тогтоол	2	2	70%
3.	ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	4	4	56.6%
4.	Ерөнхийлөгчийн зарлиг	5	9	73.3%
5.	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	11	11	71.8%
6.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2	2	85%
7.	АИТХ-ын, Тэргүүлэгчдийн тогтоол	9	9	68.9%
8.	Аймгийн ЗД-ын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт	10	22	71.54%
Нийт		47	63	70.89%

Хяналтад авсан тогтоол, шийдвэрийн явцад хийсэн үнэлгээг ангилан харуулбал:

Хяналтад авсан тогтоол, шийдвэрийн тоо	Бүгд	Шийдвэрийн ангилал							
		МУ-ын хууль	МУИХ-ын Байнгын хорооны тогтоол	УАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	Аймгийн ИТХ-ын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
Заалтын тоо	63	4	2	4	9	11	9	2	22
Үнэлгээ	Бүрэн хэрэгжсэн /100%/				1	2	1	1	5
	Хэрэгжих шатанд /70%/	46	4	2	2	8	8	7	14
	Хэрэгжилт хангалтгүй /30%/	6			1		1		3
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	1			1				
	Огт хэрэгжээгүй /0%/								
Хэрэгжилтийн дундаж хувь	70.89%	70%	70%	56.6%	73.3%	71.8%	68.9%	85%	71.54%

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн эрчимжүүлэх шаардлагатай заалтууд

№	Зүйл, заалт	Шийдвэрийн огноо, дугаар	Биелэлт	Хариуцагч
1.	2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	/УАБЗТ/ Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай №60/40, 2019-12-31	Гэр хорооллын иргэдийн ус хангамжийн эх үүсвэрийг хөрсний бохирдлоос хамгаалж, эрүүл ахуйн бүсэд ойр байрлалтай Дэнж багийн 20 өрхийн нүхэн жорлонг шинэчилж засварлах ажлын зураг төсвийг ХЗА-аар шинэчлэн гаргуулж, батлуулсан. Батлагдсан зураг, төсвийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерт 1 ААН оролцсон боловч тендерийн баримт бичгийн бүрдэл дутуу тул тендерээс татгалзаж, хүчингүй болсон тул тендрийг дахин зарлаад байна. Гэр хороололд өөрийн хөрөнгөөр бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулсан иргэнд 1 удаагийн урамшуулал олгох журмын төслийг Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран боловсруулж, сумын ИТХ-аар хэлэлцүүлж, дэмжигдсэн ба зохион байгуулах ажлын хэсгийг томилсон. 30%	П.Одончимэг
2.	Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх	/ЗГТШ/ "Хөрс хамгаалах, газрын доройтлыг	"Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх төлөвлөгөө боловсруулах суурь судалгаа хийлгэж, менежмент төлөвлөгөө боловсруулах" ажил	П.Энхсэлэнгэ

	<p>үндсэн чиглэлд тусгаж, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэн хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>бууруулах үндэсний хөтөлбөр" 2019-08-14</p>	<p>гүйцэтгэгч шалгаруулах тентерт оролцогч шалгараагүй тул дахин тендер зарлууллаа. 30%</p>	
3.	<p>2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.</p>	<p>"Аялал жуулчлалыг хөгжүүлэх" хөтөлбөр батлах тухай 2022-02-10 Дугаар 07/03</p>	<p>Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын зочилох үйлчилгээ үзүүлдэг 23 зочид буудал, 4 дэн буудал, 23 ресторан, зоогийн газар, 2 амралтын газрын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, мэдээллийн санг бүрдүүллээ. Мөн ЖУУЛЧДАД ЗОРИУЛСАН МОНГОЛ ЗООГ, УНДААГ ТОГТВОРТОЙ ХӨГЖҮҮЛЭХ НЬ" сэдвийн хүрээнд "Hogeca Mongolia" ГҮТББ-иас зохион байгуулагдсан Зочлох үйлчилгээ, Аялал жуулчлал, Хоол үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн салбарын чадавхийг сайжруулах төлбөртэй сургалт, зөвлөгөөнд Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг томоохон зочид буудлууд болон аялал жуулчлалын холбооны нийт 25 төлөөллийг хамруулж, аялал жуулчлалын зочлох үйлчилгээний чанар, стандартын талаар мэдлэг олгож ажиллалаа. Улсын чанартай А1001 авто замын дагуу гадаад, дотоотын аялагчдын ая тухай түр буудаллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын түр отоглох цэгийг Эрдэнэт хаалганы хажууд байгуулахаар шийдвэрлэж, эхний ээлжинд MNS5924:2015 стандартын шаардлага хангасан, 6 хүний хүчин чадалтай эко ариун цэврийн байгууламж баригдаж байгаа бөгөөд хүлээлгэж өгөөгүй байна. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт хаалга", Жаргалант сумын "Трактортой хөшөө"-ний орчмын 2 байршилд түр буудаллах цэг байгуулах байршлын мэдээллийг шинэчлэн гаргаж БОАЖЯаманд хүргүүллээ. 30%</p>	<p>Д.Осоржамаа</p>
4.	<p>4.1.5.Агаарын бохирдлыг бууруулах боломжит судалгааг хийж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, байгальд ээлтэй дэвшилтэт</p>	<p>/АЗДҮА 2020-2024/ Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, бохирдлыг бууруулах</p>	<p>Эрдэнэт хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын багуудын цахилгааны хүчдэл унадаг Рашаант, Яргуйт, Баян-Овоот, Шанд, Даваат, Уртын гол, Их залуу, Цагаанчулуут, Наран багуудад 6кВ-ын</p>	<p>П.Энхсэлэнгэ</p>

	ногоон технологийг бодлогоор дэмжинэ.		хуваариалах байгууламж дэд станц шинээр барих ажлыг Орконтех ХХК 1,397,611,788 төгрөгөөр гүйцэтгэхээр тендерт шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэл 70%-тай хэрэгжиж байна. Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 13 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог буурууллаа. Мөн ЧИП багцад 60 иргэнийг хөнгөлөлттэй нөхцлөөр хамруулахаар хүсэлтийг хүлээн авч байна. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ, НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөртэй хамтран монгол гэртэй айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцийг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах туршилтын төслийг хэрэгжүүлэхээр Баян-Өндөр сумын Цагаанчулуут багийн 24 өрхийг сонгож, нөхцөл байдлын судалгаа хийгдэж байна. Агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэр байшингаа өөрийн хөрөнгөөр дулаалж, халаалтын утаагүй технологи нэвтрүүлсэн иргэдэд орон нутгийн урамшуулал олгох журмын төслийг боловсруулж, Баян-Өндөр сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн ба зохион байгуулах ажлын хэсгийг томилсон. 30%	
5.		/АЗДҮА 2020-2024/ Байгальд ээлтэй газын хэрэглээ болон бусад үр ашигтай дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжих	"Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл"-ээр аймгийн хэмжээнд хийн хөдөлгүүртэй 1877 ширхэг, цахилгаан хөдөлгүүртэй 7 ширхэг, хосолсон хөдөлгүүртэй 9705 ширхэг тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь суурь түвшинтэй харьцуулахад хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 514 ширхэгээр, цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 7 ширхэгээр тус тус нэмэгдсэн байна. Даваат багт байрлалтай 17 дугаар сургуулийн уурын зуухыг буулгаж шинээр бүрэн автоматжуулагдсан тохируулга бүхий хяналт удирдлагын системтэй хийн түлшний усан халаалтын зуух суурилуулахаар 656.9 сая төгрөг батлагдсан. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр тендер зарлаж ажил гүйцэтгэгчээр Горгаз ХХК шалгарсан. Ажлын зураг төсөл шинээр боловсруулах ажил хийгдэж байна. 30%	П.Энхсэлэнгэ
6.	4.1.3.Хотын доторх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг стандартын түвшинд хүргэж, шинэчилнэ.	/АЗДҮА 2020-2024/ "Ногоон-Эрдэнэт" төслийг боловсруулан хэрэгжүүлэх	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2030 он хүртэл хугацаанд 20.0 сая ширхэг мод тарих "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийг боловсруулан аймгийн	Л.Батсайхан

			<p>ИТХ-ын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээтэй байхаар төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2022 онд 1.234.847 ширхэг мод, 2023 онд Дэнж багийн нутаг дэвсгэр Тарлан толгойн энгэрт 17.5 га-д ойн төгөл, Жаргалант суманд 6.6 га-д газар тариалангийн ойн зурвас, Сархиа уул, Хангал гол, Эрдэнэт хаалга орчим, Эрдэнэт голын эх, Хүрэн булгийн ам зэрэг газруудад 12.66 га талбайд нийт 1.888.068 ширхэг мод тарьсан. Мод тарих ажлыг зохион байгуулснаар 2023 онд таримал ойн хэмжээг 36.76 га талбайгаар нэмэгдүүлж, өссөн дүнгээр 92.76 га талбайд мод тарьж, ойн төгөл, зурвас, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 14 байршилд байгаль орчны менежмент төлөвлөгөө хэрэгжүүлэгч байгууллагууд болон олон нийтийн оролцоотой 32507 ширхэг мод, хоёрдугаар зорилтын хүрээнд 5 газарт ойн зурвас, ойн төгөл байгуулах зэрэг ажлын хүрээнд 12854 ширхэг мод, гурав дугаар зорилтын хүрээнд өрх бүр хашаандаа 5 ширхэг мод аяны хүрээнд 8783 ширхэг мод тарих үйл ажиллагааг тус тус зохион байгуулж, аймгийн хэмжээнд 2024 хаврын мод тарилтаар 54144 ширхэг мод тарилаа.</p> <p>Ногоон-Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 3.394.721 ширхэг мод тарьж, хөтөлбөрийн биелэлт 42.4%-тай хэрэгжиж байна.</p>
--	--	--	--

Зөвлөмж:

Төрийн албан хаагчдын ажлын төлөвлөлт, тайлагналт зэрэгт сургалт зохион байгуулж, мэдлэг мэдээллээр хангах, баримт бичиг боловсруулах ур чадварыг дээшлүүлэх, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг судалгаа, нотолгоо, баримтад тулгуурлан үнэн зөв тайлагнаж дадах, албан хаагчид бүх түвшинд ажлын гүйцэтгэлд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгох, тайлан хэрэгжилтийн талаар товч тодорхой хурангуулж, заагдсан тэмдэгтэд багтааж, үр дүнг нарийн тооцож гаргаж заасан хугацаанд мэдээлэх, тайлагнах зэрэгт онцгой анхаарах, ажлын явц, үр дүн удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах.

1.А. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХЭД:

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр 2024 онд зохион байгуулах хяналт шалгалтын төлөвлөгөөг 16 арга хэмжээг тусган БОАЖГ-ын даргаар батлуулан ажилласан боловч 2024 оны хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг гаргаж дүгнүүлээгүй, салбарын хяналтын батлагдсан төлөвлөгөөт хяналт шалгалт нь уялдаа холбоогүй давхцсан.

Орхон аймгийн хэмжээнд нийт дүнгээр:

№	Хуулийн нэр	2024.09.03 байдлаар	
		Зөрчлийн тоо	Холбогдох хуулийн заалт
1	Ойн тухай хууль	5	Ойн тухай хуулиар зөрчил гаргах гэж байсан - 7 иргэнийг зөрчил гарахаас урьдчилан сэргийлсэн. Монгол улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд заасны дагуу харьяаллаар шилжүүлсэн. -Орхон аймаг цагдаагийн газарт – 3 -Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн – 2
2	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх	0	ОБГ-т - шилжүүлэн хамтран ажилласан.
3	Усны тухай хууль	0	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйл. Усны тухай хууль зөрчих
4	Газрын хэвлий, ашигт малтмал	0	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хууль зөрчсөн
5	Амьтны тухай хууль	1	Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчсөн
6	Хог хаягдлын тухай хууль	0	Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хууль зөрчсөн Хог хаягдлын тухай хууль зөрчих гэж байсан 3 иргэнийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлсэн.
7	Ургамал хамгааллын хууль	0	Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хууль зөрчсөн
Бусад			Гомдол мэдээлэл -19
Нийт		6	

Зөвлөмж:

- Хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж дүгнүүлэх.
- Салбарын хяналтын батлагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтийн уялдаа холбоог сайжруулж, ААНБ-уудад хяналт шалгалтыг давхацуулахгүй холбогдох мэргэжилтэнгүүдийг тухай бүрт нь татан оролцуулах.

2. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ:

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 3 өргөдөл гомдол ирсэнийг үндэслэл, шалтгаан нөхцлийг тогтоож, өргөдөл гомдол гаргасан иргэдтэй холбогдож шийдвэрлэлтийн бодит байдлыг тогтоож, холбогдох дүрэм журмын дагуу бүртгэлийг хөтлөж хуулийн хугацаанд нь 100% буюу бүрэн шийдвэрлэж ажилласан байна.

№	Өргөдлийн агуулга	Гомдол гаргагчийн мэдээлэл	Шийдвэрлэсэн албан тушаалтан	Ам, утсаар хариу мэдэгдсэн байдал	Шийдвэрлэлт
1.	Гар дулаалгын багцад хамруулж өгөх тухай	Т.Бямбарагчаа 80930041	П.Энхсэлэнгэ	Иргэн өөрийн биеэр байгууллага дээр ирж хариугаа авсан.	Ажлын 5 хоногт шийдвэрлэсэн байна.
2.	Дээдэс орон сууцны ард шинээр баригдаж буй барилгын хажуу	Бат-Эрдэнэ 99091251	Т.Нямсүрэн	Иргэнд 99091251 дугаарын утсаар хариу мэдэгдсэн	Ажлын 3 хоногт шийдвэрлэсэн байна.

	талын граш яндан гарган их утаа гаргаснаас агаар бохирдуулж байгаад арга хэмжээ авч өгнө үү.				
3.	Худгийн цооног гаргуулах хүсэлт	Л.Цэцэгмаа 99356565	П.Одончимэг	Иргэн өөрийн биеэр байгууллага дээр ирж хариугаа авсан.	Ажлын 3 хоногт шийдвэрлэсэн байна.

3. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ:

БОАЖГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/15 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын дотоод журам”, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн “Журам батлах тухай” тушаалын дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэхэд Байгууллагын хэмжээнд 2024 оны 3 дугаар улиралын байдлаар газрын даргын А тушаал 19, Б тушаал 14 нийт 33 тушаалыг хуулийн хүрээнд боловсруулж батлуулсан. Үүнээс 6 тушаал нь байгууллагын дотоод журмын дагуу боловсруулж, хэрэгжилтийг хангуулсан байна.

Байгууллагын дотоод журмын 10 дахь хэсэг буюу Цалин хөлс, урамшуулал, тусламж тэтгэмж, нөхөх төлбөр дагуу 27.550.316 төгрөгийг олгож ажилласан байна.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг 5, 6, 7, 8 дугаар сард газрын даргын тушаал гаргахгүйгээр олгосон алдаа дутагдал илэрсэн байна.

Цаашид энэхүү алдаа дутагдлыг дахин давтахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай.

№	Тушаалын утга	Он, сар, өдөр	Тушаалын номер	Дотоод журмын хамаарал
1.	Ахмадууд хүндэтгэл үзүүлэх тухай	2024.01.16	А/04	Дотоод журмын 5.11-д заасны дагуу /600.000 төгрөг зарцуулсан/
2.	Дашийн Осоржамаад дэмжлэг үзүүлэх тухай	2024.04.03	А/07	Дотоод журмын 10.6-д заасны дагуу /500.000 төгрөг зарцуулсан/
3.	Урамшуулал олгох тухай	2024.06.25	А/15	Дотоод журмын 10.6.б-т заасны дагуу /18.626.103 төгрөгийг 15-н албан хаагчид/
4.	Ур чадварын нэмэгдэл олгох туай	2024.03.22	Б/04	Дотоод журмын 10.3-т заасны дагуу
5.	Ур чадварын нэмэгдэл олгох туай	2024.04.18	Б/05	Дотоод журмын 10.3-т заасны дагуу

4. ӨМЧ ХАМГААЛАХ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ХИЙХ:

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны “Журам батлах тухай” тогтоолын дагуу 5 хүний бүрэлдхүүнтэйгээр газрын даргын 2021 оны А/05 дугаар тушаалаар байгуулсан байна. Өмч хамгаалах зөвлөл үүргийнхээ дагуу байгууллагын өмч, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, ашиглалтын хугацаа дуусч ашиглагдах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах, Байгууллагын бүтцэд өөрчлөлт орж аялал жуулчлалын мэргэжилтэн шилжих болсон тул эд хөрөнгө тоног төхөөрөмжийг шилжүүлэх талаар 2 удаагийн хуралдааныг зохион байгуулж ажилласан байна. Өмч хамгаалах зөвлөл нь жилийн ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтгүй ажиллаж байна алдаа дутагдал илэрлээ.

Зөвлөмж:

Цаашид өмч хамгаалах зөвлөл төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулан ажиллаж, биелэлтийг жилийн эцэст тайлагнаж байх шаардлагатай.

5. БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХЭД :

Холбогдох хууль тогтоомжийг үндэслэн БОАЖГ-ын даргын 2023 оны А/35 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороог гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажилласан байна.

Ёс зүйн дэд хорооны гишүүдийг Төрийн албаны зөвлөл болон Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан Төрийн албан хаагчдад зориулсан “Ёс зүй” сэдэвт тус бүр нь 12 цагийн 3 үе шаттай модульчилсан цахим сургалтад хамруулж, бүгд амжилттай төгсөж сертификатыг гардан авлаа.

Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хорооноос санаачлан гэр бүлийн, байгууллагын ёс зүйн боловсролыг дэмжих чиглэлээр “Болор үйлсийн үндэс” ТББ-тай хамтран "Сайн эцэг эх, Төрийн албан хаагчийн ёс зүй сэдвийн хүрээнд сургалтыг 2024 оны 05 сарын 29-ний өдөр байгууллагын нийт албан хаагчдад зохион байгуулсан байна.

Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан инфографик, нийтлэл, зурагт хуудас мэдээллийг байгууллагын цахим хуудас, байгууллагын пэйж хуудсаар 4 удаа нийтлэх ажлыг зохион байгуулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын газрын веб boajg.or.gov.mn сайтыг ажиллуулж байна. Мөн Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын фэйсбүүк хуудсаар өдөр тутмын болон цаг үеийн талаарх 83 мэдээллийг бэлтгэж, 7705 иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл болон НҮБХХ, Мерит төсөлтэй хамтран зохион байгуулдаг Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагын өөрчлөлт, бүтээмжийг нэмэгдүүлэх 7:4:10 сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулж ажилласан байна.

Зөвлөмж:

- БОАЖГ-ын даргын 2023 оны А/35 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороог шинчлэх./ Ёс зүйн дэд хорооны 1 гишүүн өөр байгууллага руу шилжсэн тул /
- Жил бүр байгууллагын албан хаагчдад ёс зүйн чиглэлээр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан БОГ-ын даргаар батлуулж, хэрэгжүүлэн тайлганан ажиллах.

6. БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ НИЙГМИЙН БАТЛАГААГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХЭД:

Сургалтын төлөвлөгөө болон нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөг боловсруулан БОАЖГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажилласан боловч сургалтын төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр гаргаж дүгнүүлээгүй, харин нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний биелэлтийг 3 чиглэлийн хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж 2024 оны хагас жилийн байдлаар 78.3%-тай хэрэгжүүлэн ажилласан байна.

Зөвлөмж:

- Батлагдсан сургалтын төлөвлөгөөний 2024 оны хагас жилийн биелэлтийг хариуцсан албан хаагч нэгтгэн гаргаж цаг хугацаанд нь тайлагнаж ажиллахад онцой анхаарах

7.ТӨРИЙН АУДИТААР 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ БОЛОН АЛБАНЫ ДОТООД ХЯНАЛТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХЭД:

2023 оны санхүүгийн тайлангаар өгсөн аудитын төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн дагуу өгөгдсөн 4 арга хэмжээг төлөвлөгөө болгон боловсруулж БОАЖГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны хагас жилийн байдлаар гаргаж төрийн аудитын газарт хүргүүлэн ажилласан байна.

Зөвлөмж:

- Төлөвлөгөөний биелэлтийг хэтэрхий товч байдлаар гаргасан байна. цаашид биелэлтийг дэлгэрэнгүй тоон баримттай гаргаж тайлгнах.

8. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны цахим хуудсанд байршуулвал зохих 45 мэдээлэлээс жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахимд байршуулсан байх шаардлагатай байсан “2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл” 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

Зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг тогтмол мөрдөж ажиллах.

9. ЭД ХӨРӨНГИЙН КАРТ БОЛОН ЭД ХӨРӨНГӨ ХАРИУЦАГЧИЙН ГЭРЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛ, ӨӨРЧЛӨЛТӨД ХЯНАЛТ ХИЙХ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72, 73 дугаар заалтыг үндэслэн Байгууллагын 2024 оны үндсэн ба эргэлтийн хөрөнгийг Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 4 хоногийн хугацаанд гүйцэтгэж 200 нэр төрлийн 1,019,305,489 төгрөгийн бараа материалыг картаар тулгаж бүрэн бүтэн байдлыг шалгаж ажилласан байна. Тооллого явагдах хугацаанд гарсан зөрчилгүй байна.

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт НХМаягт БМ-10 маягтын дагуу 15 албан хаагчийн хэрэгцээнд эзэмшиж байгаа эд хөрөнгийг нэр төрлөөр ангилан бүртгэж, уг бүртгэлийг 3 хувь үйлдэх ёстой байсныг 2 хувь үйлдэж ажилласан байна.

Бараа материал, эд хөрөнгө гаргах баримтын бүртгэлийн карт дээр хүлээлгэж өгсөн мэдээлэл байгаа боловч буцаад хүлээж авсан бүртгэлийг хөтлөөгүй байна.

Зөвлөмж:

- Складанд байгаа эд хөрөнгийг картжуулж агуулахын бүртгэлийг хөтлөх,
- Бараа материал, эд хөрөнгө гаргах баримт бүртгэлийн картанд буцааж хүлээж авсан талаар мэдээллийг тусгах
- Ажилтан, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн картыг журмын дагуу 3 хувь үйлдэж 1 дүгээр хувийг санхүүгийн албанд, 2 дугаар хувийг аж ахуйн эрхлэгч (нярав)-д, үлдэх хувийг эд хариуцагчид өгөх.

10. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТ

БОАЖГ-ын даргын 2024 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2024 онд хөтлөгдөх хөтлөх нэрийн жагсаалтын дагуу дотоод хяналт

шалгалтыг гүйцэтгэхэд Байгууллагын хэмжээнд байнга-26, түр-9, 70 жил хадгалах-2 нийт 37 хадгаламжийн нэгж байх шаардлагатай бөгөөд 2024 оны 3 дугаар улиралын байдлаар:

- 1.Удирдлага, зохион байгуулалтын холбогдолтой баримт бичиг - **бүрэн**
- 2.Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг - **4 хадгаламжийн нэгж дутуу**
- 3.Архив албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг- **бүрэн**
- 4.Санхүүгийн чиглэлээр – **бүрэн**

Жагсаалтын дагуу бүрдүүлж ирүүлээгүй материалын жагсаалт:

№	Хэргийн индекс	Хэргийн агуулга	Хадгалах хугацааны жагсаалтын зүйлийн дугаар, хадгалах хугацаа	Хариуцах албан тушаалтан
1.	1	Агаар орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд холбогдох баримт бичиг	ҮЖ-1027 байнга	Мэргэжилтэн П.Энсэлэнгэ
2.	1	Мод тарилтын төлөвлөгөө, тайлан, холбогдох материал	ҮЖ-1034 байнга	Мэргэжилтэн Л.Батсайхан
3.	1	Ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгаа, акт холбогдох баримт бичиг	ҮЖ-1034 байнга	Мэргэжилтэн Л.Батсайхан
4.	1	Аялал жуулчлалын чиглэлээр хийсэн ажлын төлөвлөгөө, тайлан, холбогдох материал	ҮЖ-31 байнга	Мэргэжилтэн Ч.Одончимэг

Зөвлөмж:

Байгаль орчны газарт 2024 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу материалуудыг 1 дүгээр улиралд багтааж архивт хүлээлгэж өгөх шаардлагатай. Дутуу байгаа 4 хадгаламжийн нэгж бүхий баримт бичиг, материалуудыг яаралтай нөхөн бүрдүүлж архивт хүлээлгэж өгөх, цаашид цаг хугацаанд нь архивт хүлээлгэж өгөхөд онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

12. тайлант оны төсвийн хуваарь, санхүүжилт, гүйцэтгэл, зарцуулат, тайлагналтад хяналт хийх:

Тайлант оны байгаль орчныг хамгаалах төсөл хөтөлбөрт зарцуулах санхүүжилтийн хуваарийг 2024 оны 03 дугаар сарын 18-ний өдөр газрын даргаар батлуулж 8 төсөл хөтөлбөрийг 134,300,000 төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Байгаль хамгаалах арга хэмжээний зарцуулалт нь 2024 оны 3 дугаар улиралын байдлаар 108,130,500 төгрөгийг зарцуулж 80.52%-ийн гүйцэтгэлтэй буюу 26.169.500 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орхон аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 8 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ /Үндсэн/-ээс хархад Нийт 559,472,700 төгрөгийг зарцуулахаас 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 484,381,599 төгрөгийг зарцуулж 86.58% гүйцэтгэлтэй буюу 75,091,101 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дүгнэлт:

Байгаль орчныг хамгаалах төсөл хөтөлбөрт зарцуулах санхүүжилтийн хуваарь, Байгаль хамгаалах арга хэмжээний 2024 оны зарцуулалтын мэдээ, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төсвийн гүйцэтгэлийн мэдээ /үндсэн/-г цаг хугацаанд нь гаргаж, дээд газруудад мэдээлж, зөрчил дутагдалгүй ажилласан байна.